

Тендерийн урилга

Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт хөгжлийн банк хооронд 2019 онд байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн төсөл”-ийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Бичил хорооллыг хангах 2ф400мм шугам шинээр татах ажлын Багц-1, Багц-2”-ын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер тус банкны худалдан авах ажиллагааны цахим портал ECEPP платформд 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зарлагдана.

Тендер нь нэг үе шаттай, олон улсад нээлттэй зарлагдах бөгөөд сонгон шалгаруулалтыг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны бодлого журмыг баримтлан явуулна.

Сонирхсон эрх бүхий хуулийн этгээд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны платформд <https://ecepp.ebrd.com/> хаягаар бүртгүүлж, тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй авч болно.

Эрчим хүчний яам

Улаанбаатар Дулааны Сүлжээ ТӨХК